



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Нэрийн дансны 2016 оны орлогод тооцох
хүүгийн хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэл, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 1/252 дугаар албан тоотоор ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2016 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 7.9 хувиар баталсугай.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Мэндбаяр)-т ДААЛГАХ нь:

а/ Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны улирал бүрийн орлогод хүү тооцох ажлыг дараа улирлын эхний сард багтаан хэрэгжүүлж ажиллах.

б/ Нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад улирал бүрийн эхний сард багтаан мэдээлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Б.Болормаа)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ